



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/201

Булган сум

Шууд худалдан авах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн тавилга, тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгч “БСБ МЕБЕЛЬ” ХХК-тай 9 008 900 (Есөн сая найман мянга есөн зуу) төгрөгөөр, “БСБ ЭЛЕКТРОНИКС” ХХК-тай 939 700 (есөн зуун гучин есөн мянга долоон зуу) төгрөгөөр тус тус гэрээ байгуулах эрхийг Эрүүл мэндийн даатгалын хэлтэс (Б.Ариунболд)-т олгосугай.

2.Нийлүүлж буй бараанд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Эрүүл мэндийн даатгалын хэлтэс (Б.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан барааг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “БСБ МЕБЕЛЬ” ХХК-ийн ахлах худалдааны зөвлөх (Ж.Болорцэцэг), “БСБ ЭЛЕКТРОНИКС” ХХК-ийн менежер (М.Уранбайгаль) нарт тус тус даалгасугай.

4.Тус барааг хууль, журам, гэрээний дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010176